



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Үндэсний баялгийн сангийн 2025 оны
төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

Олон улсын геополитикийн нөхцөл байдал, худалдаа, эдийн засагт тулгарч буй тодорхойгүй нөхцөл байдлаас шалтгаалж урд хөрш БНХАУ-д эдийн засгийн өсөлт, гангийн хэрэглээ буурсан нь манай улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрсний үнийн бууралт үргэлжилж улмаар төсвийн орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлөх суурь шалтгаан болж байгаатай холбогдуулан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын төсөөллийг гадаад зах зээл дэх үнэ ханшийн өөрчлөлттэй уялдуулан бууруулж тооцох шаардлагыг бий болгож байна.

Түүнчлэн, Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын бодлогын дагуу “Ирээдүйн өв сангийн хөрөнгөөс төв банканд гадаад валютаар хадгаламж байршуулах гэрээ”-г 2025 оны 03 сарын 07-ны өдөр Монголбанктай нэг жилийн хугацаатай байгуулж, Ирээдүйн өв сангийн 1,260.0 сая ам.долларын хөрөнгийг гадаад валютын нөөцөд дарамт үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэн Англи, Франц улсуудын төв банкнуудад дунджаар 4.39 хувийн хүүтэйгээр байршуулж, тус гэрээний дагуу эхний 90 хоногийн хадгаламжийн хүүгийн орлого болох 12.8 сая ам.доллар 2025 оны 06 дугаар сарын 12-ний өдөр Ирээдүйн өв сангийн дансанд төвлөрсөн болно.

Иймд, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, уг хуулийн төсөлд Ирээдүйн өв сангийн орлогын эх үүсвэрийг гадаад зах зээлийн нөхцөлтэй уялдуулж шинэчлэх, тус санд 2025 онд төвлөрөх хөрөнгө оруулалтын өгөөжийн орлогыг мөн тусгасан.

---oOo---